



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 14

№ 01/28 ДУА -2018/28/СТА -ОНТС Мандалговь хот

Г

Зөрчлийг арилгуулах тухай

7

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дэрэн сумын Орон нутгийн хөгжлийн сантийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад 12,000,000.00 /арван хоёр сая/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь 8,000,000.00 /найман сая/ төгрөгийн авлагыг иргэнтэй тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгүй гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/ заасныг;


2. Сангийн хөрөнгөөс 4,000,000.00 төгрөгийг сумын иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, зориулалт бус “Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн авто машины урсгал засвар хийх” зардалд зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5.-д /батлагдсан төсвийг зориулатын дагуу зарцуулах;/, 60 дугаар зүйлийн 60.3-т /Орон нутгийн хөгжлийн сантийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно/, 60.3.1.-д /орон нутгийн төсвеес санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ/, 60.3.6-д /орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ/, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн засвар батлах тухай” журмын 7 дугаар зүйлийн 7.4.7.г/-д /Сумын эмнэлэг, лаборатори, эхийн дийн амрах байрны засвар үйлчилгээ, тохижилт. тоног төхөөрөмж/ заасныг тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын салах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн

төлбөрийг барагдуулах, зорчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтруулэн зарцуулжс, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн;/, 4.1.4-т /Байгууллага иргэдтэй ууссан материаллаг буюу насыжилт ондортай авлага, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй;/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Харилцагч байгууллагатай авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулах ажлыг зохион байгуулах.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 онд Төсвийн тухай хуулийн шаардлагыг хангаагүй, зориулалтын бус зардалд зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг жагсаалтаас хасч тодотгох,
3. Төсвийн хуулийн шаардлагыг хангаагүй, зориулалтын бус зардалд зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг жагсаалтаас хасч тодотгох,
4. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, зөрчлийг арилгасан талаар 2018 оны 03 дугаар сарын 01-ний дотор, зориулалт бус зарцуулалттай холбоотой зөрчлийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор арилгаж, албан шаардлагын биелэлтийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Дэрэн сумын Засаг дарга Н.Мядагмаа, нягтлан бодогч С.Цэдэрлхам нарт хариуцуулав.



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцаач албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.